

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн эрдмийн зөвлөлийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)-ийн Эрдмийн зөвлөл нь Монгол улсын Дээд боловсролын тухай хууль, холбогдох эрх зүйн бусад баримт бичиг болон МУБИС-ийн дүрмийн хүрээнд МУБИС-ийн хөгжлийн бодлого, сургалт, эрдэм шинжилгээ, оюуны өмчийн талаар баримтлах бодлого, чиглэлийн судалгаа, арга зүйн үндсийг тогтоох, хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах эрх бүхий эрдмийн хамт олон (багшлах бүрэлдэхүүн)-ы төлөөллийн дээд байгууллага мөн.

Хоёр. Эрдмийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1. Эрдмийн зөвлөл нь боловсролын доктор, түүнээс дээш эрдмийн зэрэгтэй 45 гишүүнтэй байна. Эрдмийн зөвлөл нь МУБИС-ийн захирал, бүрэлдэхүүний сургуулиас сонгогдсон гишүүдээс бүрдэнэ.

2.2. Эрдмийн зөвлөлд бүрэлдэхүүний сургуулиас гишүүдийг сонгохдоо Эрдмийн зөвлөлийн нийт гишүүний тоонд тухайн сургуулийн эрдмийн зэрэг, цолтой үндсэн багш нарын тоог пропорционалиар хувааж, оногдох квотыг тогтооно. Нэр дэвшигчдээс үндсэн багш нарын нууц санал хураалтаар сонгоно.

2.3. Эрдмийн зөвлөл нь дарга, орлогч дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга, салбар хороодтой байна. Эрдмийн зөвлөлийн дарга нь МУБИС-ийн дүрмийн 4.3.1-д заасны дагуу захирал байна. Орлогч дарга нь Эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал байна. Эрдэмтэн нарийн бичгийн даргыг Эрдмийн зөвлөлийн дарга санал болгож, нууц санал хураалтаар сонгоно. Нийт гишүүдийн 75 ба түүнээс дээш хувийн санал авсан тохиолдолд сонгогдсонд тооцно.

2.4. Эрдэмтэн нарийн бичгийн даргад МУБИС-д 8-аас доошгүй жил ажилласан, докторын зэрэгтэй, дэд профессор, түүнээс дээш цолтой Эрдмийн зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлнэ.

2.5. Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь Эрдмийн зөвлөлийн хуралд бэлтгэх, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнг гаргаж мэдээлэх болон бичиг хэргийн ажлыг гүйцэтгэх бөгөөд түүний сургалтын цагийн ачааллыг 3 кр-ээр хөнгөлнө. Энэхүү хөнгөлөлтийг Багшийн ажиллах журмын 4.2.11-д хамааруулахгүйгээр тооцно.

2.6. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн сонгуулийг 3 жил тутамд явуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт гарсан тухай бүр өмнөх сонгуулийн үр дүнг үндэслэн нөхөн сонгоно.

2.7. Эрдмийн зөвлөл нь Сургалт, Эрдэм шинжилгээ, Санхүү-эдийн засаг, Гадаад харилцаа хамтын ажиллагаа, Оюуны өмчийн гэсэн 5 салбар хороотой байх бөгөөд

хороо тус бүр 7-11 гишүүнтэй байна. Эрдмийн зөвлөлийн гишүүн нэг салбар хорооны гишүүн байна. Салбар хороодод Эрдмийн зөвлөлийн хурлаас эсвэл гишүүд өөрөө нэрээ дэвшүүлж сонгогдоно. Хорооны дарга, нарийн бичгийн даргыг гишүүд дундаасаа илээр сонгоно. Салбар хороодын дарга, бүрэлдэхүүнийг эрдмийн зөвлөлийн тогтоолоор баталгаажуулна.

2.8. Салбар хороод нь үйл ажиллагаагаа жил тутам төлөвлөх ба хэрэгжилтийг Эрдмийн зөвлөлд тайлагнана.

2.9. Салбар хороо нэмж байгуулах, татан буулгах асуудлыг Эрдмийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

2.10. МУБИС-ийн бүрэлдэхүүний сургуулиуд Эрдмийн зөвлөлтэй байна.

2.11. МУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоолыг Эрдмийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Эрдмийн зөвлөлийн чиг үүрэг

3.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Эрдмийн зөвлөлийн хурал байна.

3.2. Эрдмийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.1. Сургуулийн дүрэм, бүтэц, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн санал, зөвлөмж гаргах;

3.2.2. Сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах нийтлэг журмыг хэлэлцэн батлах;

3.2.3. МУБИС-ийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг жил бүр Эрдмийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч, Удирдах зөвлөлд хүргүүлэх;

3.2.4. Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний бодлого, үзэл баримтлал, бүтцийг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

3.2.5. МУБИС-ийн хүндэт цол, шагнал бий болгох, олгох;

3.2.6. Эрдмийн зөвлөлийн 15 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг МУБИС-ийн эрдмийн цол (дэд профессор, профессор)-д нэр дэвшигчдийн бүтээлийг МУБИС-ийн Эрдмийн болон хүндэт цол олгох журмын дагуу үнэлж, дүгнэлт гаргана. Ажлын хэсэгт Эрдмийн зөвлөлийн гишүүд ээлжлэн ажиллана.

3.2.7. Энэ журмын 3.2.6-д заасан ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийн дагуу нууцаар санал хурааж, МУБИС-ийн эрдмийн цол (дэд профессор, профессор) олгох асуудлыг шийдвэрлэх;

3.2.8. Эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлөөс шаардсан тохиолдолд бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоолыг үндэслэн, МУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоол гарган, Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хүргүүлэх;

3.2.9. Улс орны нийгэм, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, технологийн хөгжил, бодлого, судалгааны чиглэлээр төр, засгийн дээд байгууллагад өргөн барих хөтөлбөр, зөвлөмж, судалгааны болон хуулийн төсөлд өгөх санал зэргийг хэлэлцэж дүгнэлт гаргах;

3.2.10. Салбар хороод нь үйл ажиллагааны чиглэлийн дагуу Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнг хэлэлцэн, дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлтээ Эрдмийн зөвлөлийн хуралд оруулах;

3.2.11. Эрдмийн зөвлөлийн гишүүний дэвшүүлсэн асуудлыг холбогдох салбар хороогоор хэлэлцэн, олонх дэмжсэн тохиолдолд санал дүгнэлт гарган эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэх зэрэг болно.

Дөрөв. Эрдмийн зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

4.1. Эрдмийн зөвлөлийн гишүүний эрх:

4.1.1. Эрдмийн зөвлөлд хэлэлцсэн асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

4.1.2. Гаргасан саналыг хэрхэн хүлээн авсан, шийдвэрлэсэн талаар асууж тодруулах, хариу авах;

4.1.3. Эрдмийн зөвлөлийн хуралд таслах эрхтэй оролцох;

4.1.4. Эрдмийн зөвлөлд сургуулийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг хэлэлцүүлэхээр салбар хороогоор дамжуулан санал оруулах;

4.1.5. Эрдмийн зөвлөлийн салбар хороонд нэрээ дэвшүүлэх;

4.1.6. Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, шалгаж дүгнэх ажлын хэсэгт оролцох;

4.1.7. Эрдмийн зөвлөлийн гишүүнээс өөрийн хүсэлтээр татгалзах;

4.2. Эрдмийн зөвлөлийн гишүүний үүрэг:

4.2.1. Эрдмийн зөвлөлийн хурал, бусад үйл ажиллагаанд цахимаар болон биечлэн оролцох;

4.2.2. Эрдмийн зөвлөл, салбар хорооноос чиг үүргийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

4.2.3. Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг бүрэлдэхүүний сургууль, тэнхим, нэгжид мэдээлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад биечлэн оролцож ажиллах;

4.2.4. Эрдмийн зөвлөлийн гишүүн нь ээлжит хурлын тов, холбогдох баримт бичгийг хүлээн авсан болон хуралд оролцох боломжгүй тухайгаа Эрдэмтэн нарийн бичгийн даргад тухай бүр мэдэгдэж байх;

4.2.5. Тус журам болон хурлын дэгийг баримтлах зэрэг болно.

Тав. Бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүтэц, чиг үүрэг

5.1 МУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн адил үйл ажиллагааны үндсэн хэлбэр, бүтэц бүхий байна.

5.2 Эрдмийн зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргатай байна. Эрдмийн зөвлөлийн дарга нь бүрэлдэхүүний сургуулийн захирал байна. Орлогч дарга, нарийн бичгийн даргыг Эрдмийн зөвлөлийн дарга санал болгож, нууц санал хураалтаар сонгоно.

5.3 Эрдмийн зөвлөлийн гишүүдийн тоог тэнхим, нэгжийн төлөөллийг хангаж, 15-аас хэтрэхгүй байхаар тухайн сургуулийн Захирлын зөвлөлийн хурлаар тогтооно. Эрдмийн зөвлөлд гишүүдийг сонгохдоо тэнхим, нэгжийн төлөөллийг зохих ёсоор хангах ба тэнхим, нэгжийн эрдмийн зэрэгтэй багш нарын тоонд пропорционалаар

хувааж, оногдох квотыг тогтоон сонгоно. Эрдмийн зөвлөлийн сонгуулийг 3 жил тутамд явуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт гарсан тухай бүр өмнөх сонгуулийн үр дүнг үндэслэн нөхөн сонгоно.

5.4 Дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.4.1. Тухайн сургуулийн хөгжлийн бодлого, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны бодлого, тэргүүлэх чиглэлийг тогтоох;

5.4.2. Бүрэлдэхүүний сургуулийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг жил бүр Эрдмийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч, МУБИС-ийн Эрдмийн зөвлөлд хүргүүлэх;

5.4.3. Бүрэлдэхүүний сургуулийн хэмжээний боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний бодлого, үзэл баримтлал, бүтцийг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

5.4.4. Бүрэлдэхүүний сургуулийн ахисан түвшний сургалтыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр ажиллах;

5.4.5. Бүрэлдэхүүний сургуулийн хүндэт цол, шагнал бий болгох, олгох;

5.4.6. Улс, олон улсын судалгааны төслийн техникийн саналыг тухайн мэргэжлийн 3 хүртэлх эрдэмтнээр өргөтгөн хэлэлцэж, батлах;

5.4.7. МУБИС-ийн эрдэм шинжилгээний төсөл, тэтгэлэг, эрдмийн цол (дэд профессор, профессор)-д нэр дэвшигчдийн бүтээлийг үнэлж, дүгнэлт гарган, МУБИС-ийн Эрдмийн зөвлөл, Эрдэм шинжилгээний албанд мэдүүлэх;

5.4.8. Докторын зэрэг горилсон ажлыг тухайн мэргэжлийн 3 хүртэлх эрдэмтнээр өргөтгөн хэлэлцэж, Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоол гарган, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжлах;

5.4.9. Үйл ажиллагааг жил тутам төлөвлөж, хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашдын зорилго, чиглэлийг тогтоож, үйл ажиллагааны тайланг МУБИС-ийн Эрдмийн зөвлөлд хүргүүлэх зэрэг болно.

5.5. Бүрэлдэхүүний болон салбар сургуулийн Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга МУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн Эрдэмтэн нарийн бичгийн даргын адил үүрэг хүлээх бөгөөд түүний сургалтын цагийн ачааллыг 2 кр-ээр хөнгөлнө. Энэхүү хөнгөлөлтийг Багшийн ажиллах журмын 4.2.11-д хамааруулахгүйгээр тооцно.

5.6. Бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн МУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүний 4.1.4-т зааснаас бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ;

5.7. МУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын дэгийг удирдлага болгоно.

Зургаа. Эрдмийн зөвлөлийн хурлын дэг

6.1. Эрдмийн зөвлөлийн ээлжит хурлын товыг Эрдэмтэн нарийн бичгийн дарга 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд зарлаж, хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох баримт бичгийн төслийг цахимаар хүргэнэ.

6.2. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 75 ба түүнээс доошгүй хувь буюу 34-өөс дээш тооны гишүүн биечлэн (цахимаар) ирснээр хурлын ирц бүрдэнэ.

6.3. Эрдмийн зөвлөлийн хурлыг Эрдмийн зөвлөлийн дарга удирдана. Түүний эзгүйд Эрдмийн зөвлөлийн орлогч дарга удирдана. Эрдмийн зөвлөлийн хурал эхлэхэд хурал даргалагч хэлэлцэх асуудалтай уялдуулан хурлын дэгийн талаар

санал гаргаж, гишүүдийн олонх зөвшөөрснөөр дэгийг батлан, хурлыг удирдана.

6.4. Эрдмийн зөвлөлийн гишүүн нь Эрдмийн зөвлөлийн хүндэтгэлийн хувцсыг анхны болон хаалтын хуралдаан, эрдмийн цол олгох үеэр өмсөнө.

6.5. Эрдмийн зөвлөл нь хэлэлцэж буй асуудлыг тухай бүрд нь ил болон нууц санал хураалтаар эцэслэн шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.

6.6. Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр нь санал хураалтад оролцсон гишүүдийн 75 ба түүнээс дээш хувийн санал авснаар хүчин төгөлдөр болно.

6.7. Хурлын үеэр эрдмийн зөвлөлийн дарга, гишүүд МУБИС-ийн ёс зүйн дүрмийг баримтална.

6.8. Эрдмийн зөвлөл нь тогтоол, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна. Эрдмийн зөвлөлийн тогтоол, албан бичигт Эрдмийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж, МУБИС-ийн тэмдэг дарж баталгаажуулна.

6.9. Эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэлийг Эрдэмтэн нарийн бичгийн дарга хөтөлж, Эрдмийн зөвлөлийн дарга баталгаажуулна.